



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/347

Чингис хот

Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч
нарыг үргэлжлүүлэн ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ийн "а", 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.12 дахь хэсэгт заасны дагуу 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Ерөнхий болсвсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг томилох, чөлөөлөх эрх сумын Засаг дарга нарт олгогдсон тул хавсралтад дурдсан сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг нөхөн байгуулж, үргэлжлүүлэн ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сумын Засаг дарга нарыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

201010423